

“Давж заалдах шатны шүүхийн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.

Улаанбаатар

2021

АГУУЛГА

УДИРТГАЛ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	5
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	5
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	7
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	7
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	8
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	8
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	9
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	9
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	10
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх байдал	10
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх байдал 13	
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	24
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	36

АГУУЛГА

Удиртгал

Товчилсон үг

Хүснэгтийн жагсаалт

Зургийн жагсаалт

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

- 1.1. Үнэлгээ хийх шалтгаан
- 1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- 1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт
- 1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр
- 1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

- 3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх байдал
- 3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх байдал

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- 4.1. Үнэлэлт, дүгнэлт
- 4.2. Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн захиалгаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Давж заалдах шатны шүүхийн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэхтэй холбоотой” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Давж заалдах шатны шүүхийн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэхтэй холбоотой” хууль”-ын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгаа нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл гарч буй эсэх, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалт байгаа эсэх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинж байгаа эсэх, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, цаашид зохистой үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, дүгнэх гэсэн үндсэн дөрвөн үе шатаас бүрдэх болно.

Тус үнэлгээг МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн ухааны доктор Д.Гангабаатар ахалж, Өмгөөллийн “БЭЗ Партнерс” ХХН-ийн гишүүн, хуульч Л.Загдаа, хуульч Т.Энхжаргал нарын бүрэлдэхүүнтэй баг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн болно.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ИХШХШТХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХШХША	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа
ЗХШХШТХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХШХШТХ	Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ОХУ	Оросын холбооны улс
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХТХҮДҮХ аргачлал	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.4 “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ” гэсэн заалтын үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид ХТХҮДҮХ аргачлал гэх/-ын дагуу үнэлгээ хийлээ.

ХТХҮДҮХ аргачлалын 2.1-д заасны дагуу үнэлгээ хийх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэв.

ХТХҮДҮХ аргачлалын 3.1.1-д зааснаар төлөвлөх үе шатанд:

- үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- үнэлгээ хийх хүрээг тогтоох
- шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- харьцуулах хэлбэрийг сонгох
- шалгуур үзүүлэлтийг томъёолох
- мэдээлэл цуглуулах арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ИХШХШТХ” гэх/ 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Хууль батлагдснаас хойш нийт 26 удаа нэмэлт, өөрчлөлт ороход үнэлгээ хийгдэж буй энэ заалт огт хөндөгдөөгүй байна.

Тухайн зохицуулалт нь давж заалдах шатны шүүхийн бүрэн эрхийг тодорхойлсон эсэх, уг бүрэн эрхийг давж заалдах шатны шүүх хязгааргүй эдлэх эсэх, хязгаартай бол хэдийд, хэрхэн, ямар хэмжээгээр хэрэгжүүлэх талаар нарийвчлан заагаагүй байна.

Монгол Улсын Дээд шүүхээс 2002 оны 7 дугаар сарын 09-ний өдөр “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 263 дугаар тогтоолд ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг тайлбарлахад анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй эсэхийг хянана¹ гэжээ.

Уг тайлбараас хойш 7 жилийн дараа Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар” нэртэй 05 тоот зөвлөмжийг гаргасан байна. Уг зөвлөмжид ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг анхан шатны шүүхийн гаргасан алдааг илрүүлэх, залруулах давж заалдах шатны

¹ Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 07 дүгээр сарын 24-ний өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 263 дугаар тогтоол, Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл, УБ., 2004 он, 135 дахь тал

шүүхийн бүрэн эрх² гэж дүгнэсэн. Ийнхүү дүгнэхдээ уг зохицуулалтыг давж заалдах шатны шүүх хэрэглэхдээ иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив болон мэтгэлцэх зарчмыг үгүйсгэж болохгүй гэжээ³.

Дээрхээс дүгнэвэл давж заалдах шатны шүүхийн хэргийг хянах бүрэн эрхийн хэмжээ нь анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй гарсан эсэхэд хамааралтай гэсэн байр суурийг Улсын Дээд шүүх илэрхийлжээ. Тэгвэл ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2 дахь хэсэгт заасан шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагын хууль ёсны байх хэсэг нь мөн хуулийн 166.4 дэх хэсэгт хамаарахгүй гэж үзэх үү гэдэг нь асуудалтай болжээ.

Монгол Улсын дээд шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарыг гаргасан. Уг тайлбарт “давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх тухай зохицуулалт нь мэтгэлцэх болон диспозитив зарчимтай нийцэж байгаа эсэх нь маргаантай байдаг”⁴ гэж тэмдэглэсэн боловч уг тайлбарын 3 дахь хэвлэлийг⁵ 2014 онд гаргахдаа ч дээр дурдсан тогтоол, зөвлөмжийн талаар огт дурдаагүй байдаг тул асуудлыг шийдвэрлэх гарц гаргаагүй гэж дүгнэхээр байна.

Манай улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /2002 оны/ шинэчлэн боловсруулах ажиллагаанд зөвлөх мэргэжилтнээр оролцож байсан ноён Ю.Ёоахимски⁶ 2004 онд “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” номыг гаргасан бөгөөд ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх зохицуулалт мэтгэлцэх зарчмыг зөрчсөнөөс гадна давж заалдах шатны шүүхийн ачааллыг нэмсэн гэж үзсэн. Улмаар тэрээр энэ зохицуулалтыг диспозитив хэм хэмжээ болгон өөрчлөх санал дэвшүүлсэн.⁷

Түүнчлэн ноён Й.Кают⁸ 2015 онд бичсэн “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” гэх номонд ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг зохигчийн бие даан удирдан явуулдаг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчмуудад харш байна гэж дурдсан.

Хууль зүйн үндэсний хүрээлэн 2018 онд “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчилсэн хийсэн үнэлгээ” гэх судалгааны

² Хуульч Б.Чимид “... тухайн байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд “ямар үйлдэл хийх”-ийг үүрэг, үүний тулд хууль зүйн талаар “ямар боломж эдлэх”-ийг эрх гэдэг бөгөөд энэ хоёрын нэгтгээд “бүрэн эрх” гэж томъёолдог”, Үндсэн хуулийн үзэл баримтлал, УБ., 2017 он, 23 дахь тал

³ Монгол Улсын дээд шүүх 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар” 05 тоот зөвлөмж, Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмжийн эмхтгэл, УБ., 2010 он, 120 дахь тал

⁴ Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2007 он, дахь тал

⁵ Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2014 он, 397 дахь тал

⁶ Тухайн үед ХБНГУ-ын Бавари мужийн Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчээр ажиллаж байсан.

⁷ Ю.Ёоахимски, Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Мюнхен хот, 2004 он, 248 дахь тал

⁸ ХБНГУ-ын Бавари мужийн Нюрнберг хотын Дээд шүүхийн тэргүүн шүүгч асан

тайланд ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалт практикт маргаан дагуулж байгааг дурдаж судалгааны шаардлагыг тодорхойлсон⁹ боловч өгсөн зөвлөмж нь хэт нэг талыг барьсан байдаг.

Тухайн зохицуулалтыг хэрхэн тайлбарлан хэрэглэснээс өөр өөр үр дагавар гарна гэж судлаач Н.Норовсамбуу дурдаж¹⁰, гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчмыг хуулиар тодорхойлж өгөх саналыг гаргасан.

Нэгтгэн дүгнэвэл ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалт давж заалдах шатны шүүхийн бүрэн эрхийг тодорхойлсон боловч уг бүрэн эрхийн хэрэгжүүлэх үндэслэл буюу урьдчилсан хэм хэмжээг тодорхойлоогүй, уг бүрэн эрхийн хэмжээ хязгаарыг тогтоогоогүйгээс хэрэглээнд алдаа гаргах боломж бүрдүүлсэн нь үнэлгээ хийх шалтгаан болсон.

Иймд энэ заалтыг өөрчлөн найруулах нь зүйтэй боловч ИХШХШТХ-ийн бусад зохицуулалтуудтай уялдуулах шаардлагатай гэж дүгнэлээ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын хүрээг “Давж заалдах шатны шүүхийн хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэхтэй холбоотой хуулийн хэрэгжилтийн үр дагавар” гэж өгөгдсөн бөгөөд холбогдох асуудал нь ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтад хамаарах юм.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

ХТХҮДҮХ аргачлалын 3.4-т зөвхөн 1 шалгуур үзүүлэлтээр тухайн асуудалд бүрэн үнэлэлт өгөх боломжгүй тохиолдолд 2 ба түүнээс дээш шалгуур үзүүлэлтийг сонгох шаардлагын хүрээнд дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин
2. Практикт нийцэж байгаа байдал

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтээр ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалт ИХШХШТХ-ийн зорилгод хүрсэн түвшинг үнэлнэ.

ИХШХШТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон.

Энэ зорилтод хүрэхийн тулд хэрэг хянан шийдвэрлэх арга хэмжээний цогц¹¹ асуудлыг ИХШХШТХ-д журамлан зохицуулсан байгаа. ИХШХША-г эмх цэгцтэй

⁹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчилсэн хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, УБ., 2018 он, 5 дахь тал

¹⁰ Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, ШЕЗ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017 дугаар 3, УБ., 2017, 83 дах тал

¹¹ Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2014 он, 13 дах тал

хэрэгжүүлэхэд тулгуур болон тусгай зарчмын хүрээнд хэм хэмжээг уялдуулан зохицуулдаг¹². Тусгай зарчмуудаас “диспозитив” буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талууд удирдах болон “мэтгэлцэх” буюу хэргийн материалыг бүрдүүлэх, түүний үнэн зөв болохыг нотлох¹³ зарчмын хүрээнд маргааныг анхан шатны шүүх хянан шийдвэрлэнэ. Анхан шатны шүүх ийнхүү хэргийг хянан шийдвэрлэх явцад алдаа гаргасан байвал давж заалдах шатны шүүх уг алдааг залруулах үүднээс хэргийн оролцогчоос гаргасан давж заалдах гомдлоор хязгаарлахгүйгээр хэргийг бүхэлд нь хянах тогтолцоог ИХШШХТХ-д журамлажээ. Иймд энэ зохицуулалтыг практикт давж заалдах шатны шүүх зөв хэрэглэж байгаа эсэх нь уг зохицуулалтын зорилгодоо хүрсэн түвшинг тодорхойлох учиртай.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтээр ИХШШХТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг давж заалдах шатны шүүх тайлбарлан хэрэглэхэд эерэг болон сөрөг үр дагавар, хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

2018 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд энэ зохицуулалтыг практикт нийцэж байгаа байдалд дүгнэлт хийхдээ давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэж шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж байгаа байдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж байна гэсэн үр дагаврыг тодорхойлсон.¹⁴ Ийнхүү асуудлыг зөвхөн нэг талаас дүгнэсэн нь учир дутагдалтай. Давж заалдах шатны шүүх хуралдаанаас гаргасан магадлалуудаас үзвэл анхан шатны шүүхийн гаргасан процессийн алдааг залруулахаас гадна материаллаг эрх зүйн хүрээнд хийсэн буруу дүгнэлт, уг дүгнэлтийг үндэслэж гарсан алдаатай шийдвэрийг залруулсан тохиолдлууд цөөнгүй байгааг дурдах нь зүйтэй байна.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Байх ёстой болон байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдснаас хойш байдал, гадаад улсын хуулийн холбогдох зохицуулалтуудыг харьцуулсан судлах, давж заалдах шатны шүүхийн магадлал судлах хэлбэрүүдийг сонгосон болно.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд

ИХШШХТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4: “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ” гэсэн зохицуулалт зорилгодоо хэр хүрсэн бэ гэдгийг тодорхойлно.

Практикт нийцэж буй шалгуурын хүрээнд

¹² Монгол Улсын дээд шүүх, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр зөвлөмж

¹³ Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2015 он, 19 дэх тал

¹⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчилсэн хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, УБ., 2018 он, 7 дахь тал

ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4: “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ” гэсэн зохицуулалтыг хэрэглэхэд тулгарч буй бэрхшээл, түүнээс үүдэн гарсан үр дагавар, зорилгодоо хэр хүрсэн эсэхийг тодорхойлно.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Шүүхийн шийдвэр, мэргэжлийн ном, нийтлэл, өгүүлэл, эмхэтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, шүүхийн статистик тоо баримтыг ашиглаж, практик ажилтан болох шүүгч, өмгөөлөгчтэй ярилцах аргыг хэрэглэсэн болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4: “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ” гэсэн зохицуулалтын хэрэгжилтийг практик ажилтан болох шүүгч, өмгөөлөгч нараас ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан болно.

Бэлэн байгаа бичгийн мэдээлэл:

Нэг. Эрх зүйн баримт бичиг

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, /Арванзургадугаар зүйлийн 14/ дэх заалт/
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль, 1952 он / 108/
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль, 1967 он /214-р зүйл/
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 1994 он, /170 дугаар зүйл/
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он
- Япон улсын Иргэний процессийн хууль /албан бус орчуулга/
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал
- Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 07дугаар сарын 09-ний өдрийн 263 дугаар тогтоол “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”
- Монгол Улсын дээд шүүх, 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр зөвлөмж “Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах шүүхийн ажиллагаа”
- Монгол Улсын дээд шүүх, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр зөвлөмж
- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 02088 дугаар магадлал.

<http://new.shuukh.mn/irgendavah/17023/view>

Хоёр. Статистик мэдээ, судалгааны тайлан, ном, сурах бичиг, эмхэтгэл, өгүүлэл

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд, эмхэтгэсэн С.Энхбаяр, Улаанбаатар хот, 2005 он, 284 дэх тал
- Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, ШЕЗ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017 он, дугаар 3
- Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмжийн эмхтгэл, Улаанбаатар хот, 2010 он
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчилсэн хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар, 2018 он
- Ю.Ёоахимски, Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Мюнхен хот, 2004 он
- Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Улаанбаатар, 2015 он
- Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Улаанбаатар, 2007 он
- Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Улаанбаатар, 2008 он
- Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Улаанбаатар, 2014 он
- Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл, Улаанбаатар, 2004 он
- Ц.Амарсайхан нар, Процессийн эрх зүй, онол, туршлага, Улаанбаатар хот, 2014 он

Гадаад хэл дээр

- Гражданский процессуальный кодекс Российской Федерации, 2002
- Гражданский Процессуальный кодекс ФРГ /орос хэл дээр, албан бус орчуулга/
- Комментарий к Гражданскому процессуальному кодексу Российской Федерации
- Коршунов Ю.А, Институт апелляционныг судов В России и зарубежный опыт деятельности апелляционных судов, Matters off Russian and International Law, 2019, Vol9, IS 2A,

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх байдал

ИХШХШТХ-ийн зорилтыг иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлсон.

Хүмүүсийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх процесс ажиллагаа нь хүний нийгмийн хөгжлийн хамгийн эхний үе шатнаас эхэлж, цаг хугацааны явцад төлөвшиж, улмаар бие даасан эрх зүйн тогтолцоо болж хөгжих байгаа. Гэвч маргаан шийдвэрлэх процесс нь хүн төрөлхтний иргэншлийн хөгжлийн түвшингээс хамаарч харилцан адилгүй байна. 1992 онд батлагдсан Үндсэн хуулиараа Монгол Улсад хүмүүнлэг иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилгыг тунхагласан ба

энэхүү эрхэм зорилгод хүрэхэд хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлж, үндсэн зарчмуудыг тодорхойлсон. Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлж 2002 онд ИХШХШТХ-ийг баталж, иргэд хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэж журмыг тогтоосон.

Иргэд хооронд үүссэн эрх зүйн маргааныг шийдвэрлэх журмыг ерөнхийд нь шүүхийн болон шүүхийн бус журам гэж хоёр ангилж болно. Аль журмаар маргаанаа шийдвэрлүүлэх нь иргэдийн өөрсдийн сонголт байдаг тул иргэний эрх зүйн маргааныг шийдвэрлэх тусгай зарчимын нэг диспозитив зарчим болдог. Хэрэв иргэд шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээр сонгосон бол уг маргаан шийдвэрлэх журам нь тэдэнд ойлгомжтой, тодорхой байлгах нь төрийн үүрэг болно. Иймд шүүх нь үндсэн хуулийн байгууллагын хувьд түүний ажиллах журам нь тодорхой зохицуулагдсан байх учиртай.

ИХШХШТХ-д маргаан шийдвэрлэх журмыг тогтоохдоо иргэд нэхэмжлэлээ гаргадаг, шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй бол хүлээн авч иргэний хэрэг үүсгэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, маргааныг шийдвэрлэдэг. Шүүх алдаатай шийдвэр гаргасан гэж үзвэл уг шийдвэрийг хянуулах тогтолцоог бий болгохдоо үйл баримтыг эцэслэн тогтоох давж заалдах шатны шүүх, эрх зүйн дүгнэлтийг эцэслэн өгөх хяналтын шатны шүүх, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин нэг удаа нягтлан үзэх үндэслэл журмыг хуульчилж өгсөн.

Судалгаанд хамрагдаж буй асуудал нь давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаанд хамаарах тул хяналтын бусад механизмд дүгнэлт өгөөгүй болно.

Иймд давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагааг ойлгомжтой, тодорхой журамлах нь ИХШХШТХ-ийн зорилгод нийцсэн эсэхийг үнэлэх гол шалгуур болох юм.

Иргэний хэргийг давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэх журмыг ИХШХШТХ-ийн III хэсэг буюу 161-171 дүгээр зүйлд зохицуулсан боловч учир дутагдалтай болсон. Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах байдлаар журамлажээ. Үүнд: давж заалдах гомдол гаргах, давж заалдах гомдлын хэлбэр, агуулгад тавигдах шаардлага, давж заалдах гомдлыг хүлээн авах, давж заалдах гомдлоос татгалзах үр дагавар, шүүх хуралдаанд оролцох эрх, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн магадлал, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл, шүүх хуралдаан явуулах журам, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах, уг гомдлыг хянан шийдвэрлэх гэжээ. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлд зохицуулахдаа хэргийг хянан шийдвэрлэх хэмжээ, хязгаарын талаар хангалттай журамлаагүй байна.

Хууль тогтоогч хүний бүх зан үйлийг нарийвчлан тогтоож хуульчилж чадахгүйтэй адил байгууллагын үйл ажиллагааг мөн хангалттай нарийн хуульчилж тогтоож чадахгүй юм. Хууль тогтоогч зарим үйл ажиллагааг зохицуулаагүй орхигдуулсан нь санаатай үлдээх буюу бүгдээрээ мэддэг гэх, эсхүл онол, практикаар нөхөх бололцоотой гэж үлдээсэн байж болно. Энэ тохиолдолд хуулийг хийдэлтэй гэж дүгнэхгүй юм.

Иймд давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хэмжээ, хязгаарын талаар зохицуулаагүй орхисныг онол болон практикт үлдээсэн эсэхийг шалгана.

Монгол Улсын дээд шүүх 2002 оны 07 дүгээр сарын 24-ний өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 263 дугаар тогтоол гаргасан, уг тогтоолын 24 дэх хэсэгт ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг тайлбарлахдаа давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээг анхан шатны шүүхийн шийдвэр **үндэслэлтэй гарсан эсэхэд** хамаарна гэжээ. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлоор хязгаарлахгүй хэрэг хянан шийдвэрлэх хүрээг анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал гэж тодорхойлсон¹⁵. Энэхүү тодорхойлсон байдал учир дутагдалтай болсон гэж дүгнэв. Учир нь анхан шатны шүүхийн шийдвэрт мөн хууль ёсны байх шаардлага тавигдсаныг ИХШХШТХ-ийн 116 дугаар зүйлийн 116.2 дах хэсэгт: “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэсэн зохицуулалтаас дүгнэнэ. Асуудал нь давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээнд анхан шатны шүүхийн шийдвэрийн **хууль ёсны байх** шаардлагыг хангасан эсэх хамаарахгүй гэж үзэх үү?

Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар” 05 тоот зөвлөмжийг гаргасан. Зөвлөмж иргэдийн шүүхэд мэдүүлэх эрхийн хэрэгжилтийг хангах, иргэний шүүн таслах ажиллагаан дахь давж заалдах шатны шүүхийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах ажиллагааг боловсронгуй болгох, шүүн таслах ажиллагааны чанарыг дээшлүүлэх зорилготой ба зөвлөмж гаргах эрх хэмжээг Улсын дээд шүүхэд хуулиар олгогдсон хэдий ч хууль тайлбарлан гаргасан тогтоолын адил хүчин төгөлдөр үйлчлэхгүй юм.

ИХШХШТХ-ийн давж заалдах шатны шүүхийн ажиллагаатай холбоотой зохицуулалтуудын хэрэглээний талаар тайлбарласан уг зөвлөмжид шүүхийн алдааг залруулах нь шүүхийн хамгаалалтын салшгүй хэсэг¹⁶, давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах ажиллагааг хэрэгжүүлэхдээ давж заалдах гомдлын үндэслэлээр хязгаарлахгүй боловч мэтгэлцэх болон диспозитив зарчмыг зөрчихгүйгээр хэрэгжүүлэх боломжтой гэсэн ерөнхий хүрээг тогтоосон.

Дээрхээс дүгнэвэл ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалт хэт ерөнхий байдлаар томъёологдсоноор хуулийн зорилтыг хангаж чадахгүй байна.

¹⁵ Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 07 дүгээр сарын 24-ний өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 263 дугаар тогтоол, Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл, УБ., 2004 он, 135 дахь тал

¹⁶ Монгол Улсын дээд шүүхийн 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар” 05 тоот зөвлөмж, Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмжийн эмхэтгэл, УБ., 2010 он, 117 дахь тал

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтээр ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг давж заалдах шатны шүүх тайлбарлан хэрэглэх эерэг болон сөрөг үр дагавар, хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

Шүүхийн практик. Давж заалдах шатны шүүх ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтын хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хянахдаа 3 төрлийн шийдэл гаргасан байна. Үүнд:

- A. Анхан шатны шүүхийн гаргасан техникийн шинжтэй алдааг залруулсан. Техникийн шинжтэй алдаанд хуулийн заалтыг буруу бичсэн, зохигчийн нэрийг буруу бичих, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилахдаа зарим зохигчийн талаар бичилгүй орхигдуулах, шийдвэрийн удиртгал хэсэгт шүүх хуралдааны оролцогчдыг буруу нэрлэн заасан, хуульд байхгүй заалт баримталсан, тооцооллын алдаа гаргасан зэргийг оруулан тооцжээ.
- B. Материаллаг эрх зүйн дүгнэлт буруу хийсэн тохиолдолд давж заалдах шатны шүүх дүгнэлтийг өөрчилж анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байна. Жишээлбэл, талуудын хооронд үүссэн маргаанд хамаарах хуулийн холбогдох зохицуулалтыг буруу хэрэглэсэн, нарийвчилсан хуулийн зохицуулалтыг баримтлаагүй, эрх зүйн зөрүүтэй дүгнэлт хийх, хүүхдийн асрамжийн талаар дүгнэлт хийгээгүй, улмаар шийдвэрлээгүй орхигдуулсан, алдангийн талаар хийсэн талуудын тохиролцоо хуульд нийцээгүй байхад алдангийг гаргуулж шийдвэрлэсэн, эд хөрөнгийн эзэмшлийн талаарх маргаанд өмчлөх эрхийн шаардлагатай холбоотой дүгнэлт хийсэн, эрх зүйн маргааныг зөв тодорхойлоогүй зэрэг алдаануудыг залруулсан байна.
- C. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн буюу процессын дараах алдааг илрүүлсэн байна. Үүнд: хэргийн оролцогчид хэргийн материал танилцуулаагүй, хэрэгт баримтгүй байхад дүгнэлт хийсэн, бичмэл нотлох баримтын шаардлага хангаагүй баримтад дүгнэлт хийсэн, нэхэмжлэлээс татгалзах эрх олгогдоогүй этгээдийн хүсэлт шийдвэрлэсэн, шинжээчийн дүгнэлт хуулийн шаардлага хангаагүй байхад дүгнэж шийдвэрийн үндэслэл болгосон, нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй байхад тодруулалгүй хэргийг шийдвэрлэсэн, гомдлоор авч хэлэлцэх маргаанд нотлох баримт дутуу байхад хэргийг шийдвэрлэсэн, гуравдагч этгээдийг оролцуулаагүй, сөрөг нэхэмжлэлийг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй, нэхэмжлэлийн шаардлага шийдвэрлэлгүй орхигдуулсан зэрэг хамаарч байна.

Шүүхийн практикаас дүгнэвэл давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлоор хязгаарлалгүйгээр хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ анхан шатны шүүхээс гаргасан материаллаг болон процессийн алдааг илрүүлж, улмаар залруулах боломжтой алдааг залруулж, боломжгүй тохиолдолд шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэж байна. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх

шаардлагад нийцэж байгаа эсэхээр бүрэн эрхийн хүрээ, хязгаарыг тогтоожээ. Харин ийнхүү бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчмыг хуульд тодорхойлоогүйгээс энэ төрлийн алдаа гарах боломжтой байна. Жишээлбэл: Нэхэмжлэгч давж заалдах гомдол гаргасан. Гомдлын агуулга нь анхан шатны шүүх барьцааны гэрээнд заасан хөрөнгийг шүүхийн шийдвэрт дурдалгүй орхигдуулсан тул шүүхийн шийдвэрт уг хөрөнгийг тусгуулах байжээ. Давж заалдах шатны шүүх барьцааны зүйл болох амины орон сууцаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан нь давж заалдах гомдлын хүрээнд асуудлыг шийдвэрлэсэн зөв боловч анхан шатны шүүхээс зээлийн гэрээний үүргийг хангаж шийдвэрлэсэн хэмжээг багасгаж шийдвэрлэсэн нь алдаатай болсон. Учир нь нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг анхан шатны шүүх 202 530 483 төгрөгөөр хангаж шийдвэрлэсэн ба хариуцагч энэ шийдэлд гомдол гаргаагүй тул талуудын зарчмыг үндэслэн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн энэ шийдэлд дүгнэлт өгөх учиргүй. Гэтэл давж заалдан шатны шүүх уг үнийн дүнг 196 356 483 төгрөг болгож бууруулсан нь нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан гэж дүгнэхээр байна.

Шүүхийн практикт холбогдох заалтыг хэрэгжүүлэхдээ давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчмыг хөндөж байх тул хуульд энэ зарчмын зохицуулалтыг оруулах шаардлагатай.

Харин техникийн шинжтэй алдааг залруулах нь тухайн шатны шүүхийн эрх хэмжээнд хамааруулах эсэх, эсхүл дээд шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааруулах эсэх асуудлыг хууль тогтоогч шийдвэрлэх учиртайг шүүхийн практик харуулж байх бөгөөд энэ судалгааны зүйл биш болохыг нэмж дүгнэлээ.

Тайлбар, зөвлөмж

Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 07 дүгээр сарын 24-ний өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 263 дугаар тогтоолын 24 дэх хэсэгт хуулийн холбогдох заалтыг тайлбарлахдаа анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй эсэхийг давж заалдах шатны шүүх гомдолд дурдсанаар хязгаарлахгүйгээр хэргийг бүхэлд нь хянана гэж заажээ. Уг тогтоол нь хуулийн хэм хэмжээнд тусгагдаагүй урьдчилсан нөхцөлийг тодорхойлсон бөгөөд ийнхүү тодорхойлохдоо давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй эсэхийг хянахаар заасан нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх гэх шалгуурыг орхигдуулсан гэж дүгнэхээр байна.

Өмнө дурдсанчлан Улсын дээд шүүхээс 2007, 2008, 2014 онд гаргасан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”-т ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн тайлбарлахдаа энэ зохицуулалтыг мэтгэлцэх болон диспозитив зарчимтай нийцэж байгаа эсэх нь маргаантай¹⁷ гэдгийг дурдсан. Гэхдээ уг тайлбарын ИХШХШТХ-ийн 167 дугаар зүйлд заасан анхан шатны шүүхийн

¹⁷ Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, УБ., 2014 он, 397 дах тал

шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээх буюу өөрчлөх хэсгийг тайлбарлахдаа гомдолд дурдаагүй үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг өөрчлөхөд шүүх талуудын байдлыг “дордуулахгүй” байх зарчмыг баримтлах нь зүйтэй¹⁸ гэжээ. Улмаар хэргийг бүхэлд нь хянах нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагатай гэж үздэг судлаачдын тайлбарыг дэмжсэн гэж дүгнэхээр байна. Дээрх тайлбараас дүгнэвэл ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг хэрэглэхэд мэтгэлцэх, диспозитив болон гомдол гаргагчийн байдлыг “дордуулахгүй” байх зарчмыг харгалзан үзэхийг анхааруулжээ.

Харин Улсын дээд шүүхээс 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар” 05 дугаар зөвлөмжид давж заалдах шатны шүүх дээд шатны шүүхийн хувьд анхан шатны шүүхийн алдааг залруулах эрх хэмжээний хүрээнд давж заалдах гомдолд дурдаагүй үндэслэлд дүгнэлт хийх эрх хэмжээг ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтаар олгосон нь ИХШХША-ны үндсэн зарчмуудыг зөрчих үндэслэл болохгүй¹⁹ гэжээ. Үүнээс дүгнэвэл давж заалдах шатны шүүх энэ зохицуулалтыг хэрэглэх хүрээг диспозитив болон мэтгэлцээний зарчмаар хязгаарлагдсан байх ба энэ агуулгыг хуульд тусгайлан зохицуулаагүй нь хууль хэрэглээний хувьд хүндрэлийг бий болгосон байна.

ХБНГУ-ын Бавари мужийн Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч Юпп Ёоахимски нь манай 2002 оны ИХШХШТХ-ийг анх тутам тайлбарлаж, 2004 онд “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” номыг 2004 онд хэвлүүлсэн. Түүний үзэж байгаагаар ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн заалтыг боловсронгуй болгох шаардлагатай гээд ийнхүү боловсронгуй болгохдоо энэ зүйлийг диспозитив хэм хэмжээ болгож өөрчлөх нь зүйтэй гэжээ.²⁰ Энэ саналыг гаргасан хэмжээгээр дэмжих боломжгүй нь Монгол Улсын дээд шүүхийн албан бус тайлбараас харагдаж байна.

Нийтлэл, судалгаа, мэргэжлийн ном

А. Мөн ХБНГУ-ын Бавари мужийн Нюрнбергийн Дээд шүүхийн тэргүүн шүүгчээр ажиллаж байсан Йоахим Кают нь “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” номыг 2015 онд бичиж хэвлэн нийтлүүлсэн. Манай улсын 2002 оны ИХШХШТХ-д нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийж 2014 оны байдлаар хүчин төгөлдөр байгаа хуулийн заалтуудын хүрээнд саналаа илэрхийлсэн байна. Тэрээр тодорхойлоо ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалт диспозитив зарчимд харшилж байгаа ба гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулж

¹⁸ Мөн тэнд, 402 дахь тал

¹⁹ Монгол Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, хэмжээ, хязгаар” 05 тоот зөвлөмж, Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмжийн эмхтгэл, УБ., 2010 он, 119-120 дахь тал

²⁰ Ю.Ёоахимски, Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Мюнхен хот, 2004 он, 248 дахь тал

болохгүй гэсэн²¹. Үүнээс дүгнэвэл хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээ нь гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байхаар хязгаарлагдах учиртай байна.

Б. Судлаач Н.Норовсамбуу “Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим” нийтлэлийг Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид ШЕЗ гэх/ -өөс “Шүүх эрх мэдэл” сэтгүүлийн 2017 оны 3 дугаарт нийтлүүлжээ. Нийтлэлд ИШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалтыг хэрхэн тайлбарлаж хэрэглэхээс үр дагавар гарна гэж дүгнэсэн²². Энд “хянан үзэх”, “шийдвэр гаргах” гэдгийг салгаж үзвэл ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийг талуудын зарчмыг зөрчиж байна гэх, эсхүл шүүхийн шийдвэрт хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагатай зөрчилдөнө гэх шаардлагагүй болох бөгөөд уг зохицуулалтыг байх ёстой жам ёсных гэж үнэлжээ.²³ Улмаар уг зохицуулалтыг давж заалдах шатны шүүхэд олгосон “эрх хэмжээ” гэж ойлговол талуудын зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжих суурь зарчимтай зөрчилдөнө гэсэн саналыг гаргасан. Улмаар Япон улсын Иргэний процессийн холбогдох зохицуулалттай харьцуулж гомдол гаргагчийн ашиг сонирхлыг дордуулахыг хориглох зарчмыг давж заалдах шатны шүүх хэрэгжүүлэх нь давж заалдах эрхийн баталгаа болох учиртайг тайлбарлажээ.²⁴

В. 2018 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд энэ зохицуулалтыг практикт нийцэж байгаа байдалд дүгнэлт хийхдээ давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан шийдвэрлэж шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж байгаа байдлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж буй сөрөг үр дагавар гарч байна гэжээ. Ийнхүү асуудлыг зөвхөн нэг талаас нь дүгнэсэн нь учир дутагдалтай бөгөөд хангалттай биш болжээ.

Өмнөх хуулийн зохицуулалт

1994 оны ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлийн 3-т “Давж заалдах журмаар хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол, эсэргүүцэлд дурдсан үндсээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй”²⁵ гэж заажээ. 2002 оны ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэг болох “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ” гэсэнтэй харьцуулбал 1994 оны хуулиас “эсэргүүцэл” бичдэг байсан тогтолцоог халсантай холбогдуулж уг үгийг заалтаас хассанаас өөрөөр өөрчлөлт ороогүй байна. Иймд уг зохицуулалт 1994 оны хуулиас уламжлагдан иржээ.

1967 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хуулийн 214-р зүйл “Хоёрдугаар шатны шүүхийн хэрэг хянан хэлэлцэх хязгаар”-т “Хоёрдугаар

²¹ Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, УБ., 2015 он, 230-231 дэх тал

²² Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, ШЕЗ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017 он, дугаар 3, 83 дахь тал

²³ Мөн тэнд

²⁴ Мөн тэнд, 86 дахь тал

²⁵ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд, эмхэтгэсэн С.Энхбаяр, УБ., 2005 он, 284 дэх тал

шатны шүүх нь доод шатны шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэстэй болсон эсэхийг хэрэгт байгаа ба хэргийн оролцогчдын шинээр ирүүлсэн бичмэл материалын²⁶ дагуу шалгана. Хоёрдугаар шатны шүүх зөвхөн давж заалдсан гомдол буюу эсэргүүцэлд заасан үндэслэлээр хязгаарлахгүй, хэргийг бүхэлд нь, мөн давж заалдаагүй этгээдэд холбогдох хэсгийг нэгэн адил хянан хэлэлцэх үүрэгтэй. ...”²⁷ гэж заажээ. Энд давж заалдах журмаар хэргийг хянаж буй шүүх хэргийг бүхэлд нь хянах ажиллагааг явуулах үүрэгтэй байхаар тусгасан бөгөөд зүйлийн гарчиг нь хоёрдугаар шатны шүүхийн хэрэг хянан хэлэлцэх хязгаар гэж томъёолсон нь хуулийн техникийн хувьд оновчтой байсныг дурдах нь зүйтэй байна.

1952 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хуулийн 108-д “Дээд шүүх нь давж заалдсан гомдлыг хянан үзэхдээ гагцхүү гомдолд дурдсан зүйлийг хянан шалгаад зогсохгүй ирүүлсэн бүх хэргийг шалгах журмаар хянан үзэх үүрэгтэй болно”²⁸ гэжээ. Мөн энд хэргийг бүхэлд нь хянах үүргийн хүрээнд зохицуулсан байжээ.

Харин 1926 оны Монгол Ард Улсын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хуульд²⁹ холбогдох зохицуулалт үгүй байна.

Хүснэгт 1. Өмнө болон одоо үйлчилж байгаа ИХШХШТХ-иудын холбогдох зохицуулалт

№	Хууль баталсан он	Хуулийн нэр	Заалт
1	1926 он	Монгол Ард Улсын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль	Холбогдох зохицуулалт байхгүй
2	1952 он	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль	108-д “Дээд шүүх нь давж заалдсан гомдлыг хянан үзэхдээ гагцхүү гомдолд дурдсан зүйлийг хянан шалгаад зогсохгүй ирүүлсэн бүх хэргийг шалгах журмаар хянан үзэх үүрэгтэй болно”

²⁶ Энэ судалгааны хүрээнд давж заалдах шатны шүүх шинэ баримт хэлэлцэх эсэх асуудал ороогүй тул эхний өгүүлбэрийн тэр хэсэгт дүгнэлт өгөөгүй болно.

²⁷ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд, эмхэтгэсэн С.Энхбаяр, УБ., 2005 он, 178-179 дэх тал

²⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд, эмхэтгэсэн С.Энхбаяр, УБ., 2005 он, 81 дэх тал

²⁹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд, эмхэтгэсэн С.Энхбаяр, УБ., 2005 он, 25 дахь тал

3	1967 он	1967 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль	214-р зүйл “Хоёрдугаар шатны шүүхийн хэрэг хянан хэлэлцэх хязгаар” –т “Хоёрдугаар шатны шүүх нь доод шатны шүүхийн шийдвэр хууль ёсны ба үндэстэй болсон эсэхийг хэрэгт байгаа ба хэргийн оролцогчдын шинээр ирүүлсэн бичмэл материалын дагуу шалгана. Хоёрдугаар шатны шүүх зөвхөн давж заалдсан гомдол буюу эсэргүүцэлд заасан үндэслэлээр хязгаарлахгүй, хэргийг бүхэлд нь, мөн давж заалдаагүй этгээдэд холбогдох хэсгийг нэгэн адил хянан хэлэлцэх үүрэгтэй. ...”
4	1994 он	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	170 дугаар зүйлийн 3-т “Давж заалдах журмаар хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол, эсэргүүцэлд дурдсан үндсээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй”
5	2002 он	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	166 дугаар зүйлийн 166.4-т “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ”

Дүгнэвэл судалгаанд хамрагдаж буй хуулийн зохицуулалт 1952, 1967, 1994 оны процессийн хуулиудаас тухайн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан өөрчлөн найруулагдаж ирсэн уламжлалтай байна. Монгол Улс социалист системтэй байх үедээ Оросын холбооны улсын хуулиудыг бараг хуулах шахам авч хэрэглэж байсан³⁰ тул ОХУ-ын Иргэний процессийн хуулийн зохицуулалтуудыг судлах нь зүйтэй байна.

Захиргаа болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт

Хүснэгт 2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хуулиудын холбогдох зохицуулалтуудыг харьцуулах нь

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016 он	Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт “Давж заалдах журмаар хэрэг хянан	118 дугаар зүйлийн 118.3 дах хэсэгт “Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг	9.1 дүгээр зүйл. “Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ” 1.Давж заалдах шатны шүүх

³⁰ Мөн тэнд, 6 дахь тал

<p>шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ”</p>	<p>давж заалдах гомдлын хүрээнд хянах ба хэргийн хоёр, түүнээс дээш оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй”.</p> <p>118.4.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн бол гомдлоор хязгаарлахгүй.</p>	<p>гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянана.</p> <p>3.Шүүх давж заалдсан гомдол, эсэргүүцэлд заасан асуудлаар хязгаарлахгүй ба бусад ял шийтгүүлсэн, цагаатгагдсан этгээд давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн эсэхийг харгалзахгүйгээр хэргийг бүхэлд нь хянаж үзнэ.</p> <p>4.Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж болно.</p> <p>7.Шүүх дараах үндэслэл тогтоогдвол хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргана:</p>
--	---	--

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.3 дахь хэсгээс дүгнэвэл давж заалдах шатны шүүх давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянах ерөнхий зохицуулалтыг тусгаад ерөнхий зохицуулалтыг өөрчилж буй тусгай зохицуулалтыг хэргийн хоёр, түүнээс дээш оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд хэргийг бүхэлд нь хянан үзэх үүрэгтэй гэж хуульчилжээ. Түүнчлэн мөн зүйлийн 118.4 дэх хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн нь шүүхийн шийдвэр гарахад нөлөөлсөн бол гомдлоор хязгаарлахгүй” гэж заасан нь анхан шатны шүүхээс процессийн алдаа гаргасан бол давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан үзэх эрх хэмжээтэй болохыг заажээ. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд давж заалдах шатны шүүхийн хэрэг хянах бүрэн эрхийн нарийвчлан тогтоосон нь давуу талтай болсон байна.

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйл. “Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ” гэж нэрлэн зааж, зохицуулсан нь ойлгомжтой, хууль зүйн техникийн хувьд нэр томъёог зөв хэрэглэсэн байна. Уг зүйлээр журамласан

ажиллагаа цэгцтэй, дараалалтай байгаагаас үзэхэд хэрэглээнд хялбар байдлаар тогтоосон гэж дүгнэхээр байна. Шүүмжлэлтэй хандахад зарим томъёоллыг оновчгүй хийсэн боловч манай судалгаанд хамаарахгүй тул дүгнэхгүй орхив.

Гэхдээ захиргааны болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь официал зарчмыг хэрэгжүүлдэг тул иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчмыг харгалзан үзэх ёстойг дурдах нь зүйтэй.

ОХУ-ын Иргэний процессийн хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулбал

Хүснэгт 3. Харьцуулалт

№	Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	ОХУ-ын Иргэний процессийн хууль	Тайлбар
Зүйлийн гарчиг	Байхгүй	327.1 дүгээр зүйл “Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хязгаар”	Манай хуульд давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хязгаарыг тогтоосон зүйлийг тусгайлан зохицуулаагүй. ИХШШТХ-ийн 166 дугаар зүйл “Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх” гэх хэсэгт 4 дүгээр заалт болж орсон байгаа.
Заалтын дугаар	Шууд зохицуулсан заалтгүй,	1. Давж заалдах шатны шүүх давж заалдах гомдол, уг давж заалдах гомдолд гаргасан тайлбар, татгалзлын хүрээнд хэргийг хянан хэлэлцэнэ. ³¹	Манай хуульд шууд зохицуулсан заалтгүй. ИХШШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн агуулгаас тайлбарлаж болно.
	166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсэгт “Давж заалдах	1. Шийдвэрийн тодорхой хэсэгт гомдол гаргасан бол давж заалдах шатны	ОХУ-ын хуулийн эн зохицуулалтын эхний өгүүлбэртэй дүйцэхүйц зохицуулалт манай хуульд

³¹ Энэ заалтын дараагийн 3 өгүүлбэрийг орчуулалгүй орхив. Учир нь орчуулагдаагүй 3 зохицуулалт нь давж заалдах шатны шүүхэд хэргийн оролцогчоос шинээр гаргаж өгсөн нотлох баримтыг хүлээн авах эсэх, хүлээн авсан бол үнэлэхтэй холбоотой байна.

	<p>журмаар хэрэг хянан шийдвэрлэж буй шүүх зөвхөн гомдол дурдсан үндэслэлээр хязгаарлалгүй хэргийг бүхэлд нь хянан үзнэ</p>	<p>шүүх шийдвэрийн хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байдлыг гомдолд заасан хэмжээнд хянан.</p> <p>Давж заалдах шатны шүүх шийдвэр хууль ёсны байх хуулийн шаардлагын үүднээс шийдвэрийг бүхэлд нь хянах эрхтэй.</p>	<p>байхгүй.</p>
		<p>2. Давж заалдах гомдолд дурдсан эсэхээс үл хамаарч давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүх энэ хуулийн 330 дугаар зүйлийн 4³² дэх хэсэгт заасан анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрхийн зохицуулалтыг зөрчсөн эсэхийг хянан.</p>	<p>Манай хуулийн 166 дугаар зүйлд байхгүй зохицуулалт.</p>

ОХУ Иргэний процессийн хуульдаа давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хүрээг нарийвчлан тогтоож өгсөн байна. Уг хуулийн 1 дүгээр заалтаар давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээг тодорхойлсон буюу анхан шатны шүүхийн шийдвэрийг хянах хэмжээг давж заалдах гомдлын хүрээгээр

³² Энэ хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил буюу залруулах боломжгүй нөхцлийг заажээ.

хязгаарласан³³. ОХУ-ын судлаачид холбогдох зохицуулалтдаа шүүмжлэлтэй ханддаг ч манай хуулийн зохицуулалт энэ түвшинд зохицуулагдаагүй тул тэдний судлаачдын дүгнэлтийг энд дурдах шаардлагагүй гэж үзсэн болно.

ОХУ-ын холбогдох хуулийн зохицуулалтаас үзвэл манай хуульд хийсэн судлаачдын дүгнэлт, саналыг хүлээн авах нь зүйтэй байна.

ОХУ-ын хуульд ерөнхий зохицуулалтаа давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах гомдлын хүрээнд хянана гэж тодорхойлж, тусгай буюу дүрмийн бус зохицуулалтад шийдвэрийн хууль ёсны байдлыг хангах үүднээс давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээг олгожээ³⁴. Давж заалдах шатны шүүх үйл баримтыг эцэслэн тогтоодог тул энэ шатанд нэмэлт нотлох баримтыг авч болох журамтай.

ХБНГУ болон Япон Улсын Иргэний процессийн хуулийн зохицуулалтаас үзвэл тэдгээр улсын давж заалдах шатны шүүх холбогдох зохицуулалттай харьцуулбал

ХБНГУ-ын Иргэний процессийн хуульд давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах гомдлын хүрээгээр хянадаг байна³⁵. Гэхдээ давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх, сөрөг нэхэмжлэлийг харилцан тооцох, сөрөг нэхэмжлэл гаргах, давж заалдах шатны шүүхэд цугларсан нотлох баримтыг үнэлж /ХБНГУ-ын Иргэний процессийн хуулийн 533 дугаар зүйл/ хэргийн шийдвэрлэх онцлогтой. ХБНГУ-ын Иргэний процессийн эрх зүйд давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулах шийдвэр гаргахыг хориглодог ойлголттой.³⁶ Учир нь шүүхийн шийдвэрт гомдол гаргасан нэхэмжлэгч нь өөрийн эрх зүйн байдлыг дордуулна гэж биш харин дээрдүүлнэ гэж бодож гомдол гаргадаг.³⁷

Япон улсын Иргэний процессийн хуулийн зохицуулалтаар давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан эрх хэмжээтэй байна³⁸. Уг процессийн хуулийн 304 дүгээр зүйлийн 304.1-д “Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох болон өөрчлөх бол гомдол гаргасан хүрээнд байна” гэж зааснаас дүгнэвэл давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг гомдлын хүрээнд хянадаг гэж дүгнэхээр байна. Нөгөө талаас нь тайлбарлах юм бол давж заалдах гомдлоор хэргийг хянахад давж заалдах гомдол гаргасан этгээдийн эрх зүйн байдал дордох нөхцөл байдал тогтоогдож болно. Гэтэл давж заалдах гомдол гаргасан этгээд энэхүү гомдлыг гаргаагүй бол түүний эрх зүйн байдал илүү дордохгүй байж болох байсан. Иймд түүний эрх зүйн байдлыг хамгийн

³³ Комментарий к Гражданскому процессуальному кодексу Российской Федерации, Проспект, Москва, 2015, 647 дахь тал

³⁴ Мөн тэнд, 648 дахь тал

³⁵ Коршунов Ю.А., Институт апелляционных судов В России и зарубежный опыт деятельности апелляционных судов, Matters off Russian and International Law, 2019, Vol9, IS 2A, p246

³⁶ Мөн тэнд

³⁷ Мөн тэнд

³⁸ Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, ШЕЗ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017 он, дугаар 3, 86 дахь тал

бага стандарт буюу гомдол гаргахгүй байх нөхцөл байдлаар тодорхойлон тогтоож байгааг хууль тогтоогч шударга гэж үзжээ. Энэ зарчмыг диспозитив зарчмаас урган гарсан зарчим³⁹ гэж үздэг байна.

³⁹ Мөн тэнд, 85 дахь тал

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.4 дэх хэсгийн зохицуулалт хэт ерөнхий байдлаар томъёологдсон, давж заалдах шатны шүүхийн бүрэн эрх, давж заалдах шатны шүүхийн хэргийг хянах хүрээ, хэмжээг тодорхойлоход учир дутагдалтай болжээ.

Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ, хэмжээ хязгаар өөр өөрөөр зохицуулагдах учиртай. Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээ, хэмжээ хязгаарыг ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийн нэг өгүүлбэрээр тодорхойлсон зохицуулалтаар бүрэн тогтоож чадаагүй байна.

Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ, хязгаарыг тогтоож шийдвэрлэх нь процессийн хууль тогтоомж дахь давж заалдах шатны шүүхийн мөн чанарыг агуулах чухал зохицуулалт болох юм.

Хууль зүйн техник талаас авч үзсэн ч аливаа асуудлыг шийдвэрлэхэд ерөнхий зохицуулалтыг тодорхойлох учиртай. Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчим нь давж заалдах гомдлыг үндэслэн хэргийг хянах тул юуны түрүүнд хэрэг хянан шийдвэрлэх хүрээг тогтооход давж заалдах гомдлын хэмжээгээр харгалзан үзэх юм. Иймд ерөнхий зохицуулалтын хүрээнд хуульд давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах гомдлын хүрээнд хянана гэх санааг оруулах нь зүйтэй.

Шүүхийн практикаас дүгнэвэл анхан шатны шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагад нийцсэн эсэхээр давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээг тодорхойлсон байна. Анхан шатны шүүх материаллаг эрх зүйн дүгнэлт хийхдээ алдаа гаргаж, процессийн ажиллагааг буруу явуулсан нь хэргийн шийдэлд нөлөөлөх хэмжээний алдаа гаргадаг бөгөөд давж заалдах гомдол гаргаж буй этгээд төдийлэн энэ алдаануудыг анхааралгүй, ач холбогдол өгөөгүй нь гомдлын агуулгаас харагддаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд заавал өмгөөлөгч оролцох журам байхгүй тул хэргийн оролцогч хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлоо хангалттай хамгаалж чадах эсэх нь эргэлзээтэй байдаг. Иймд давж заалдах шатны шүүхээс гомдолд дурдаагүй үндэслэлээр хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээ нь иргэний эрх зүйн маргааныг зөв хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх, шүүхийн алдааг залруулах процессийн эрх зүйн баталгаа болдог. Иймд давж заалдах гомдолд дурдаагүй ч хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээг давж заалдах шатны шүүхэд олгох нь зүйтэй бөгөөд харин энэ эрх хэмжээний хязгаар, хүрээг тодорхойлж өгөх учиртай. Үүнээс дүгнэвэл давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хэргийг хянасан боловч шүүхийн шийдвэр алдаатай хэвээр байх үр дагавар үүсч байвал шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагад нийцэхгүй хэвээр байна. Энэ алдааг залруулах нь зүйтэй боловч энэ талаар гомдол гараагүй нөхцөлд давж заалдах шатны шүүхэд хуулиар эрх хэмжээ олгох учиртай. Ийнхүү энэ эрх хэмжээ нь хязгааргүй байж болохгүй тул хуулиар хязгаарлалт буюу бүрэн эрхийг

хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөлийг тодорхой болгох ёстой. Энэ урьдчилсан нөхцөл нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шалгуурт нийцээгүй байх явдал юм.

Ийнхүү тусгай зохицуулалтын хүрээнд давж заалдах шатны шүүхэд хэргийг бүхэлд нь хянах эрх хэмжээ олгосон бол энэ эрх хэмжээ хаана хүрээд зогсох талаар зохицуулах учиртай. Энэ шалгуур нь давж заалдах шатны шүүх эрх хэмжээг хэрэгжүүлэхдээ давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх зарчим болно.

4.2. Зөвлөмж

Хуулийн холбогдох заалтыг өөрчлөн найруулахад дараахь зөвлөмжийг хүргүүлж байна. Зөвлөмжийн үндэслэлийн 4.1 дэх хэсэгт хангалттай тайлбарласан тул дахин давтах шаардлагагүй гэж дүгнэсэн болно. Үүнд:

1. Ерөнхий зохицуулалтын хүрээнд давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг тогтоохдоо гомдол гаргагчийн давж заалдах гомдлоор хязгаарлах
2. Ерөнхий дүрмийг өөрчлөх тусгай дүрмийн хүрээнд шүүхийн шийдвэрийн хууль ёсны байдлыг хангахын тулд давж заалдах шатны шүүх хэргийг давж заалдах гомдлоор хязгаарлагдахгүй хянах эрх хэмжээтэй байх.
3. Ийнхүү шүүхийн шийдвэрийн хууль ёсны байдлыг хангахдаа гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх стандартыг тогтоох.
4. Судалгаанд хамаарахгүй ч хууль уялдаа холбоотой байх шаардлагын хүрээнд техник алдааг засварлах эрхийг шийдвэр гаргасан тухайн шүүхийн эрх хэмжээнд эсхүл дээд шатны шүүхийн эрх хэмжээнд өгөх эсэхийг хууль тогтоогч шийдвэрлэх нь зүйтэй.

Судалгаа.1 Техникийн шинжтэй алдаатай холбоотой

№	Магадлалын огноо	Нэхэмжлэгч, хариуцагчийн нэрийн товчлол	ИХШХШТХ 166.4 дэх хэсгийн дагуу хийсэн дүгнэлт	Тайлбар
1.	2020.05.08 №1014	З.Э ХГ ХХК	ИХШХШТХ 166.4 дэх хэсгийн эрх хэмжээний талаар дурдаагүй боловч ИХ 520 дах хэсгийн заалтыг баримтлах байтал ИХ 510 гэж баримталсан нь буруу тул зөвтгөсөн гэжээ.	Энэ магадлалд ИХШХШТХ 166.4 дэх хэсгийг баримталснаа дурдалгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдаг.
2.	2020.05.12 №1034	КБ ХХК СС ХХК болон Л.Б	Шийдвэрийн тогтоох хэсэгт хуулийн зүйл, заалтыг давхардуулан хэрэглэсэн, хариуцагч байгууллагын нэрийг буруу бичсэн, улсын тэмдэгтийн хураамжийг хуваарилахдаа нэхэмжлэгчийн төлсөн улсын тэмдэгтийн хураамжийн мэдээллийг орхигдуулсан техникийн шинжтэй алдаа гаргасныг дурдаж, залруулах боломжтой гэжээ.	Энэ магадлалд ИХШХШТХ 166.4 дэх хэсгийг баримталснаа дурдалгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан байдаг
3.	2020.06.26 №1374	А.Д Г.Г	Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэгт нэхэмжлэлийн шаардлага болон шүүх хуралдааны оролцогчдын өөрөөр	Залруулав.

			тодорхойлж бичсэн нь техникийн шинжтэй алдаа	
4.	2020.06.26 №1375	Б.О В.Ц, Б.Г	Хуульд байхгүй заалт баримталсныг залруулсан. ИХШХШТХ 166.4 дэх заалтын дагуу залруулга хийж буйг бичээгүй	
5.	2020.07.03 №1461	Л.О Д.Б	Хуулийн заалт буруу бичснийг залруулав.	ИХШХШТХ-ийн 166.4-ийг дурдаагүй, Залруулга нь ИХ 3434.1 гэж буруу бичснийг 343.1 гэж залруулсан
6.	2020.07.03 №1486	С.Ц ҮК ХХК, ҮГ ХХК	Хөдөлмөр хөлстэй тэнцэх олговор гаргахад тооцооллын алдаа гаргасныг залруулав	
7.	2020.07.08 №1552	АКК ББСБ ХХК Б.М	Зээлийн гэрээний үүргийг тооцохдоо тооцооллын алдаа гаргасныг залруулсан.	
8	2020.07.10 №1557	М.Б С ХХК, Д.Б, Д.О	Нэхэмжлэгчийг хариуцагч гэж буруу тодорхойлсныг зассан	ИХШХШТХ 166.4-ийг дүгнээгүй

Судалгаа 2. Материаллаг эрх зүй дүгнэлттэй холбоотой

№	Магадлалын огноо	Нэхэмжлэгч, хариуцагчийн нэрийн товчлол	ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийн дагуу хийсэн дүгнэлт	Тайлбар
1.	2020.05.13 №1049	СР ХХК У.М	Талуудын хооронд үүссэн маргаанд хамаарах хуулийн холбогдох зохицуулалтыг зөв	Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхисон. Хариуцагч хууль хэрэглээний гомдол гаргаагүй. Давж

			хэрэглээгүй гээд ИХ 204.1, 232.5 гэснийг хасч ИХ 243.1, 205.1, 227.1 гэж нэмсэн	заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дүгнээгүй.
2.	2020.05.13 №1047	Д.П Б.Ц болон СД ХХК,	Нарийвчилсан хуулийн зохицуулалтыг баримтлаагүйг залруулсан.	Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхисон. Хариуцагч хууль хэрэглээний гомдол гаргаагүй. Давж заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дүгнээгүй.
3.	2020.05.20 №1101	Ү.Б. ГБ ХХК	Анхан шатны шүүх зохигчдын хооронд ИХ 243.1-д заасан худалдах худалдан авах гэрээний харилцаа үүссэн талаар зөв дүгнэсэн атлаа үндэслэлгүй хөрөнгөжих буюу гэрээний бус үүрэгтэй холбоотой заалтыг хэрэглэсэн нь хууль хэрэглээний алдаатай болсон.	Анхан шатны шүүхийн шийдвэрт “Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1” гэснийг “Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1” гэж өөрчилсөн байна.
4.	2020.05.18 №1083	Б.А Б.Г болон ПСВ ХХК	Хууль хэрэглээний алдааг залруулсан	Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхисон. Хариуцагч хууль хэрэглээний гомдол гаргаагүй. Давж заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дүгнээгүй. ИХ 59.1, 59.2, 280.1.1 гэснийг ИХ 59.1, 59.2 гэж залруулсан
5.	2020.05.15 №1066	БЗД ЗДТГ М.Ш	Хууль хэрэглээний алдааг залруулсан	Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй

				<p>орхисон. Хариуцагч хууль хэрэглээний гомдол гаргаагүй. Давж заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дүгнээгүй.</p> <p>ИХ-ийн 496.1 гэснийг ИХ 497.1 гэж залруулсан</p>
6.	2020..05.29 №1178	МРКК шб Ж.Х	Хууль хэрэглээний алдааг залруулсан	<p>Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхисон. Хариуцагч хууль хэрэглээний гомдол гаргаагүй. Давж заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дүгнээгүй</p> <p>ИХ 492.1.1 гэснийг ИХ 318.1 гэж залруулсан</p>
7.	2020.05.29 №1170	Ц.Л ТБ ХХК	Хууль хэрэглээний алдааг залруулсан	<p>Хариуцагчийн гаргасан гомдлыг хангахгүй орхисон. Хариуцагч хууль хэрэглээний гомдол гаргаагүй. Давж заалдах шатны шүүхээс ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дүгнээгүй</p> <p>ИХ 221.3, 221.6 гэснийг ИХ 227.1, 227.3 гэж өөрчилсөн байна.</p>
8.	2020.01.17 №130	Ц.Э Ж.О	Хүүхдийн асрамжийг шийдвэрлэлгүй орхигдуулсан, залруулах боломжтой алдаа	Хүүхдийн асрамж шийдвэрлэсэн заалт шийдвэрийн тогтоох хэсэгт нэмж оруулсан
9.	2020.01.10 №72	ОТЗ ХХК ТЗ ХХК болон	Алдангийн тохиролцоо хуульд нийцээгүй	Алдангид гаргуулсан шаардлагыг

		Н.Б	байхад алдангийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн буруу	хэрэгсэхгүй болгосон өөрчлөлт оруулсан
10.	2020.01.29 №228	А.Х Б.О болон Ц.А	Нэхэмжлэгч бусдын хууль бус эзэмшилтэй холбоотой шаардлага гаргасан байхад эзэмшилтэй холбоогүй боловч өмчлөгчийн эрхийг зөрчиж байгаа этгээдийн эсрэг гаргах шаардлагад хамаарах ИХ 106.2 дах хэсгийн заалтыг баримталсан нь буруу	Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтаас ИХ 106.2 дах хэсгийн заалтыг хассан
11.	2020.03.06 №539	ФГ ББСБ ХХК Т.Э	Нэхэмжлэгч фидуцийн гэрээний зүйлээр зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн хангуулах нэг шаардлага гаргасан байхад анхан шатны шүүх зээлийн гэрээний үүрэг болон зээлийн гэрээний үүргийг фидуцийн гэрээний зүйлээр хангуулах 2 шаардлага гаргасан гэж буруу тодорхойлсныг залруулсан	Шийдвэрт өөрчлөлт оруулсан
12.	2020.06.19. №1314	Б.С.Г ТОДББ ХХК, ЭЭКМС ХХК	Тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаатай холбоотой гэрээг байгуулаад зөвшөөрөл аваагүй тохиолдолд гэрээний харилцаа үүсэхгүй тул гэрээнээс татгалзах хууль зүйн үндэслэлгүй.	ИХ 476.1, 227.3 гэснийг ИХ 56.5, 492.11 гэж өөрчилсөн

			Төлбөрийг үндэслэлгүй хөрөнгөжих үндэслэлээр шаардах эрхтэй гээд хууль хэрэглээний өөрчлөлт оруулсан	
13.	2020.06.22 №1336	Д.Б. МЭГЛ ХХК	Хууль хэрэглээ	ИХ 106.1-ийг ИХ 274.1, 100.1 болгож өөрчилсөн, ингэхдээ ИХШХШТХ 166.4-ийн эрх хэмжээний хүрээнд гэдгийг тайлбарлаагүй байна.
14.	2020.07.01 №1455	Т ХХК А.Г,А.Г	Анхан шатны шүүх урт хугацаатай гэрээний талууд гэрээнээс татгалзан цуцалж, гэрээний дагуу шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон цуцлах хүртэл хугацааны үүргийг шаардсан байхад Иргэний хуулийн зохих заалтуудыг баримтлаагүй алдааг залруулж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулав	ИХ 453.1 гэсний дараа 25-1, 225.1 гэж нэмсэн. Тайлбар. ИХШХШТХ 166.4 дэх хэсгийг дурдаагүй, өөрчлөлт оруулсан гэж дүгнэсэн атлаа нэмэлт хийсэн /ИХШХШТХ 167.1.2/, урт хугацааны гэрээг цуцалж, хохирол шаардах эрхийн зохицуулалт буруу хэрэглэсэн
15.	2020.07.01 №1453	С.О С.М	Хууль хэрэглээний өөрчлөлт	ИХ 92.1 гэснийг ИХ 106.1 гэж өөрчилсөн. Тайлбар: ИХШХШТХ 166.4 дэх заалтыг дүгнээгүй
16.	2020.07.08 №1533	Д.Т ЖХ СӨХ	Хариуцагч нь өмнөх эрх бүхий этгээдээс эрх залгамжлан авсан талаархи баримтгүй	Шүүхийн шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. Тайлбар: ИХШХШТХ 166.4-ийг дурдаагүй алдаатай
17.	2020.07.17	Л.Х	Нэхэмжлэгч	Алдааг залруулж,

	№1561	ХУД ГБХЗХХ	нэхэмжлэлээ багасгасан байхад нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсан гэж буруу дүгнэж, шийдвэрийн 2 дах заалтаар холбогдох шаардлагаас татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон алдаатай	шийдвэрт өөрчлөлт оруулсан. Гэхдээ ИХШХШТХ-ийн 166.4-ийг дүгнээгүй
--	-------	------------	--	--

Судалгаа 3 . Процессийн дүгнэлттэй холбоотой

№	Магадлалын огноо, дугаар	Нэхэмжлэгч, хариуцагчийн нэрийн товчлол	ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийн дагуу хийсэн дүгнэлт	Үр дагавар
1.	2020.03.18. №601	МГ ХХК Б.И.	ИХШХШТХ-ийн 25.1.2-т зааснаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид хэргийн материал танилцуулаагүй	Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэх
2.	2020.04.06 №789	Д.Г, Ц.Д-ийн нэхэмжлэлтэй НШШГГ	Шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг зөв тайлбарлан хэрэглээгүй.	Шийдвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулсан
3.	2020.04.27 №946	МУХБ ТОСК ХХК	Зээлийн хүүгийн талаар талууд маргасан тохиолдолд зээлийн хүү тооцсон баримт хэрэгт авагдаагүй байна.	Шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэх
4.	2020.05.20 №1093	Ч.Н. НШШГГ	Нэхэмжлэгчийн өмгөөлөгчид нэхэмжлэлийн зарим шаардлагаас татгалзах эрх олгоогүй байхад анхан шатны шүүх татгалзлыг баталж,	Нэхэмжлэгч нэхэмжлэлийн 2 шаардлага гаргасан, анхан шатны шүүх 1 нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 1

			холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон алдаатай байна. ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийг дурдаагүй байна.	шаардлагаас татгалзсан заалтуудыг нэгтгэж нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох өөрчлөлт оруулсан байна.
5.	2020.06.03 №1217	Ч.Л НДЕГ	Хариуцагч байгууллагын архивын “хуулбар үнэн” дардастай баримт нь ИХШХШТХ-ийн 38.5 дах хэсэгт зааснаар шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй	Шийдвэрийг хүчингүй, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан.
6.	2020.01.15 №110	О.О Ц.Т	Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон шинжээчийн дүгнэлт хуулийн шаардлага хангаагүй, дахин шинжээч томилох боломжтой	Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан
7.	2020.01.15 №98	Т.Ү И.О	Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй	Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан
8.	2020.01.31 №272	О ХХК ПТ ХХК	Шинжээч томилуулах тухай хариуцагчийн хүсэлтийг хангахгүй орхисон нь буруу	Шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан
9.	2020.02.03 №279	Х.Ч С.О	Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл тодорхойгүй	Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан
10.	2020.03.16 №576	ОИ ББСБ ХХК НШШГГ	Шийдвэр гүйцэтгэх баримт дутуу	Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан
11.	2020.06.19 №1317	Н.Г Ц.Ч	Гуравдагч этгээдийг оролцуулах байсан	Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэх
12.	020.06.19 №1321	Н.Г ХУД ЭМТ	Сөрөг нэхэмжлэлийг хүлээн авахаас	ИХШХШТХ 166.4 дэх хэсгийг дурдаагүй

			татгалзсан нь ИХШХШТХ-ийн 73.2 зөрчсөн.	байна. Шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан байна.
13.	2020.06.22 №1346	Ч.Т МД ХХК	Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаас хөдөлмөрлөх эрхээ сэргээлгэх хэсгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан. ИХШХШТХ-ийн 166.4-т зааснаар шийдвэрт өөрчлөлт оруулсан	
14.	2020.06.29 №1412	Н.О Ж.Ж	Хариуцагчид хэрэгт авагдсан нотлох баримт болон шүүхээс хийсэн ажиллагааны баримтуудыг танилцуулаагүй.	. Шийдвэр хүчингүй, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан.
15.	2020.07.03 №1469	НЦ ХХК АУЦ ХХК	Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохдоо хууль баримтлаагүй нь ИХШХШТХ 118.2 дах заалтыг зөрчсөн	ИХ 343.1 гэж нэмсэн. Дүгнэлтээ ИХШХШТХ-ийн 166.4- ийг дурдаагүй

Судалгаа 4. Давж заалдах гомдол гаргасан этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан

№	Магадлалын огноо, дугаар	Нэхэмжлэгч, хариуцагчийн нэрийн товчлол	Давж заалдах гомдлын агуулга	ИХШХШТХ-ийн 166.4 дэх хэсгийн хэрэглэсэн байдал, үр дүн
1.	2020.04.06 №788	ДО ББСБ ХХК Э.Ц	Нэхэмжлэгч давж заалдах гомдолдоо: “анхан шатны шүүх барьцааны гэрээнд заасан хөрөнгийг шүүхийн шийдвэрт дурдалгүй	Барьцааны зүйл болох амины орон сууцыг шийдвэрийн тогтоох хэсэгт орхигдуулсныг залруулсан нь давж заалдах гомдлын хүрээнд асуудлыг

			<p>орхигдуулсан тул нэмж оруулж өгнө үү”</p>	<p>шийдвэрлэсэн боловч анхан шатны шүүх нэхэмжлэлийг 202 530 483 төгрөгийн хэмжээнд хангаж шийдвэрлэсэн байхад 196 356 483 төгрөг болгож бууруулсан байна. Дүгнэлт: хариуцагч анхан шатны шүүхийн шийдвэр болох 202 530 483 төгрөгийн хэмжээнд давж заалдах гомдол гаргаагүй, нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан байна</p>
--	--	--	--	---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж, олон улсын гэрээ бусад эрх зүйн акт

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хуулийн 1952 он
3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний байцаан шийтгэх хууль, 1967 он
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 1994 он
5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он
6. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он
7. Монгол Улсын дээд шүүхийн 2002 оны 07 дүгээр сарын 24-ний өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 263 дугаар тогтоол
8. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 02088 дугаар магадлал.
9. Монгол Улсын дээд шүүх, 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр зөвлөмж “Анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, гомдлыг хүлээн авах шүүхийн ажиллагаа”
10. Монгол Улсын дээд шүүх, 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр зөвлөмж
11. Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

Хоёр. Судалгаа, тайлан, төсөл, илтгэл, эмхэтгэл

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуулиуд, эмхэтгэсэн С.Энхбаяр, Улаанбаатар, 2005 он
2. Н.Норовсамбуу, Иргэний процессын эрх зүй дэх давж заалдах гомдол гаргагчийн эрх зүйн байдлыг дордуулахыг хориглох зарчим, ШЕЗ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017 он, дугаар 3
3. Монгол Улсын дээд шүүхийн тогтоолын эмхэтгэл, Улаанбаатар, 2004 он, 135 дахь тал
4. Монгол Улсын дээд шүүхийн зөвлөмжийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2010 он
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчилсэн хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар, 2018 он

Гурав. Ном, сэтгүүл, гарын авлага

1. Ю.Ёоахимски, Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар, Мюнхен хот, 2004 он
2. Й.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Улаанбаатар, 2015 он
3. Монгол Улсын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар, Улаанбаатар, 2014 он

Ц.Амарсайхан нар, Процессийн эрх зүй, онол, туршлага, Улаанбаатар хот, 2014 он

Дөрөв. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Гражданский процессуальный кодекс Российской Федерации, 2002
2. Гражданский Процессуальны кодекс ФРГ /орос хэл дээр, албан бус орчуулга/
3. Комментарий к Гражданскому процессуальному кодексу Российской Федерации, Проспект, Москва, 2015
4. Коршунов Ю.А, Институт апелляционныг судов В России и зарубежный опыт деятельности апелляционных судов, *Matters off Russian and International Law*, 2019, Vol9, IS 2A, p246